



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/169

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 18.2.1, 18.2.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05, 2022 оны XII хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оныг “Хөвсгөлд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Улаанбаатар травэл экспо 2022” үзэсгэлэнд оролцох бэлтгэл ажлыг хангаж, үр дүнтэй зохион байгуулж тайлагнаж ажиллахыг аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

2. Үзэсгэлэнд оролцоход зарцуулагдах 6.600.000 (Зургаан сая зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны “Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН